

Монголчуудын "за" хэмээхүйн
уг учир

Д.Заяабаатар (МУИС)

Бодот ертөнцийн юмс үзэгдэл бүхэн хөдлөнги, зогсонги шинжтэй байдаг. Хэлний дохио нь хөдлөнги шинжтэй тул байнга хувьсан өөрчлөгдөнө. Үүнтэй шууд уялдан, монгол хэлний зарим үг хэллэгийн утга түүхэн хөгжлийн явцад ихээхэн төсөөрөн хувьсахын зэрэгцээ тэрхүү үгийн цөм утга нь тогтвортой хэллэгт ямар нэг байдлаар хадгалагддаг ажээ. Ийм онцлог бүхий үг хэллэгийн утгын хувьсал өөрчлөлтийг нэхэн шинжлэх нь ихээхэн сонирхолтой асуудал бөгөөд тэр нь угтаа монгол угсаатны ёс заншил, сэтгэлгээний онцлог, ертөнцийг үзэх үзэлтэй шууд холбогдох өргөн цар хүрээтэй судлагдахуун болно.

Бид энэ удаа монгол ярианы хэлний идэвхтэй нэгж болох "за" хэмээх үгийн утгын хувьсал өөрчлөлтийг хэлний баримт хэрэглэхүүнээс мөшгөн шинжлэх зорилго тавилаа.

Эл үгийг "Монгол хэлний товч тайлбар толь"¹-д "Бусдын хэлсэн зүйлийг дагах зөвшөөрөхөд хэлэх аялга; *заа, заа яах вэ; заа боль!*; *заа болно; заа мэдэв; заа заа* (бусдын хэлсэн тушаасныг лавтайяа хүлээн дагахад хэрэглэх аялга; *заа заа чингээ; заа заа зөвшөөрөө; бусдын хэлснийг үл ойшооход хэлэх аялга: заа болиоч; заа яршиг даа)*" гэж тайлбарлажээ.

Дундад үеийн монгол хэлний гол дурсгал болсон "Монголын нууц товчоон"-д

... dei-secen ügülerün olon-ta-wū quyu'ulju ökbesü de'ejilekdegü cö'en-te-wü quyu'ulju ökbesü doromjilaqdaqü ökin gü'ün-nü jaya'an töreksen e'üten-tür ötölgü ügei ökin-iyen be öksü kö'ün-iyen be güreget-te talbiju o[t] ke'eba **je bolulcaju** yisügei-ba'atur ügülerün kö'ü-ben gürege[t]-te talbisu kö'ü minu noqai-yaca cocimtawu büle'e

¹ Я.Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, 253дугаар тал.

quda kö'ü minu noqai-yaca bu soci'ul kē'et kötöl morin-ıyan belge ökcü temüjin-ni güreget-te talbiju otcu...²

(...Дэй сэцэн өгүүлрүүн: Олонтаа гуйлгаж өгөөс дээжлэгдэх, цөөнтөө гуйлгаж өгөөс доромжлогдох. Охин хүний заяа төрсөн үүдэнд өтлөхгүй, охиноо өгсү, хөвгүүнээ хүргэдтээ талбиж од хэмээв. **Зэ бололцож** Есүхэй баатар өгүүлрүүн: Хөвгүүнээ хүргэдтээ талбису. Хөвгүүн минь нохойноос цочимтгой бүлгээ. Худ хүүг минь нохойноос бүү цочуул хэмээгээд хөтөл морио бэлгэ өгч Тэмүжинийг хүргэдтээ талбиж одож...)

гэж гардаг. Лувсанданзаны "Алтан товч"-д "... ǰ-а kemejü quda bolulčaba"³ (...за хэмээж худ бололцов) хэмээж, утга санааг энгийн ойлгомжтойгоор тодруулан бичсэн буй.

Ийнхүү "зэ (за) бололцоод" буцах замдаа Есүхэй баатар татар нарт хорлогдож, тэр цагаас хойш балчир хөвгүүн Тэмүжин амьдралын хатуу бэрхийг биеэр туулж, зовон зүдэж ахуйдаа "хазайшгүй анд нөхрийг танин түшиж, хэлбэршгүй шулуун шударгыг эрхэмлэн дээдлэх"-ийн тус эрдмийг бүрнээ ухаарч, "эл зөийн хүч, эсрэг булха-гийн мөхөс"-ийг гүнээс гүн ойлон мэдсэн талаар "Монголын нууц товчоон"-д нэн тодорхой өгүүлсэн билээ.

Харин Тэмүжиний амьдрал ахуй тарчиг дутуу, амь нас сэлэмний ир, жадны үзүүрт байсан тэрхүү хүнд хүчир цаг үед тал нутгийн язгууртан Дэй сэцэн өөрийн ганц охин Бөртэ-ийн хувь заяанд өчүүхэн ч эргэлзэлгүй, түүний гэргий болгон өгдөг билээ. Эл хэрэг явдлын чанад учир нь урьд өмнө Есүхэй баатартэй хэлэлцэн тохирч, "зэ (за) бололцсон"-д оршино. Өөрөөр хэлбэл, Есүхэй баатрыг амьд ахуйд нь "за" хэмээн зөвшөөрсөн нь тухайн үед үл зөрчих бичигдээгүй хууль мэт байсан ажээ.

"Монголын нууц товчоон"-ы 108дугаар зүйлд:

... temüjin to'oril-qan jaqa-gambu qurban qamtutcu tendece gödö[ll]jü onan-nu teri'ün botoqan-bo'orji-da gürbesü jamuqa boljäl qajar-a qurban üdür urida gürcü'üi jamuqa ede temüjin to'oril jaqa-gambu-tan-u ceri'üd-i üje'e[t] jamuqa qoyar tümet ceri'üd-ıyen jasaju bayıju'ui ede ber temüjin to'oril-qan jaqa-gambu-tan ceri'üd-ıyen jasa'at-gü gürölcejü jici tanılduju jamuqa ügülerün boro'an ber bolu'asu boljäl-tur qura ber bolu'asu qural-tur bu qojıdaya ese-'ü ke'eldüle'ei bida mongqol **je andaqartan busut-ü je-dece qojidaqsan-i jerge-dece qarqaya** ke'eldüle'ei ke'eba jamuqa-yin üge-tür to'oril-qan ügülerün boljäl qajar-a qurban üdür qojit bayıba ke'en qodulaqu-yi cimarlaqu-yı jamuqa de'ü medetügei ke'eba⁴

² [SHM §66]; I.de Rachewiltz, "Index to the secret history of the mongols", Bloomington, 1972, p.26.

³ *Altan tobč*, Эх бичгийн фото хэвлэл, Оршил бичиж, хэвлэлд бэлтгэсэн Ш.Бира, Улаанбаатар, 1990, 14b.

⁴ [SHM §108]; I.de Rachewiltz, "Index to the secret history of the mongols", Bloomington, 1972, p.44.

(...Тэмүжин, Тоорил хан, Жаха-хамбу гурав хамтдаж тэндээс хөдөлж, Ононы тэргүүн Ботохан-бооржид хүрвээс Жамуха болзоол газраа гурван өдрийн урьд хүрчээ. Жамуха эд Тэмүжин, Тоорил, Жаха-хамбутаны цэргүүдийг үзээд цэргээ засаж байжухуй. Эд бээр Тэмүжин, Тоорил хан, Жаха-хамбутан цэргүүдээ засаад хүрэлцэж, жич танилдаж, Жамуха өгүүлрүүн: Бороо ч болбоос болзоолд, хур ч болбоос хуралд бүү хождъё хэмээлдлээ. **Бид монгол зэ андгаартан** (андгай тангарагтан Д.3) **бус уу. Зэ-гээс хождсоныг зэргээс гаргая** хэмээлдлээ хэмээв. Жамухын үгэнд Тоорил хан өгүүлрүүн: Болзоол газраа гурван өдөр хожд байв хэмээн годлох чамарлахыг (яллах зэмлэх Д.3) Жамуха дүү мэдтүгэй хэмээв)

гэж буй.

Академич Б.Ринчен, энэхүү хэллэгийг тухайлан тайлбарлаж, "андагаар гэж андгай тангараг гэсэн үг. *Андгай, андагаар, тангараг* гэж утга ойролцоо хэдэн үг манай баялаг хэлнээ буй. Саяхи цэцэн үгийн учир утга нь сүрхий гүнзгий. "Бидний монголчууд нэг л за гэвэл даруй ам тангараг, андагаар, шахаан өргөсөнтэй адил" гэсэн утгатай бөгөөд хүнд юм амлавал "за" гэсэн чинь цаад хүний өмнө ам өгснөө заавал биелүүлж байх ёстой гэсэн дээд боловсон зарчим ёс манай өвгөд дээдэст байжээ"⁵ хэмээн тэмдэглэжээ.

Үнэхээр XIII зууны үеийн "hodutai tenggeri horciju büle'e olon ulus bulqa büle'e oron-dur-iyān ülü oron oljalaldun büle'e körisütei etügen körbejü büle'e gür ulus bulqa büle'e könjile-degen ülü gebten görüleldün büle'e"⁶ цагт "зэ (за) боллолцсоноо"-оо умартана гэдэг өршөөн хэлтрүүлшгүй алдаа эндэл байсан биз ээ.

Тиймээс, "Бороо ч болбоос болзоонд, хур ч болбоос хуралд бүү хождъё" хэмээж, "**зэ (за) боллолцсон**" атал, түүнийгээ зөрчиж, осол омтгой болсон Тоорил хан, Тэмүжин хоёрт хандаж, Жамуха андын хэлсэн "**зэ-гээс хождсоныг зэргээс гаргая**" гэх хатуу үгийн учир зангилаа нь мөнхүү андгай тангарагт оршино.

Академич Х.Пэрлээ⁷, энэ талаар тухайлан бичсэн өгүүлэлдээ, XIII зууны үед монголчуудын баримталж байсан болзооны хэв хуулийн нэгэн зүйл хэмээн тодорхойлсон билээ.

⁵ Б.Ринчен, *Монголын за андагаар буй за*, Улаанбаатар, 2002, 251дүгээр тал.

⁶ [SHM §254]; I.de Rachewiltz, "Index to the secret history of the mongols", Bloomington, 1972, p.150.

Одтой тэнгэр орчиж бүлгээ

Олон улс булха (тэмцэн тулалдаж Д.3) бүлгээ

Орондоо үл орон олзлолдон бүлгээ

Хөрст этүгэн (газар Д.3) хөрвөж бүлгээ

Хүр (бүх бүгд Д.3) улс булха (тэмцэн тулалдаж Д.3) бүлгээ

Хөнжилдөө үл хэвтэн гөрлөлдөн (довтлолдон) бүлгээ.

⁷ Х.Пэрлээ, "Нууц товчоонд үлдсэн хууль цаазын зарим зүйл", Гурван өгүүлэл, Улаанбаатар, 1962. 27дугаар тал.

XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалын дотор чухал байрыг эзлэх Ил хаан Өлзийтөөс Францын хаан Филиппт 1305 онд илгээсэн албан бичигт

"...Edüge tngri-yin kücün-dür bida yeke or-a sayuysan-dur uridus sayid abüge [=äbüge=ebüge] sayin açige [=äçige=eçige] sayin aqayuban jrly jasay-i busi ülü bolyan belen jasaysan möri uridus sayid-luy-a **j-e kemeldügsen-i ülü talbin andayayar metü sedkijü** uridaqiyača ülemji amralduju ilčin-iyen ileldün ay-a kemen sedkijü an buyu ba⁸

(...Эдүгээ тэнгэрийн хүчинд бид их ор суусанд урьдас сайд өвөг сайн эцэг сайн ахынхаа зарлиг засгийг биш үл болгон, бэлэн зассан мөрийг урьдас сайд лугаа зэ *хэмээлдсэнийг үл талбин андгаар мэт сэтгэж* урьдахиас үлэмж амралдаж, элчээ илгээлдэн байя хэмээн сэтгэж байн буюу бид)

хэмээн тэмдэглэсэн буй.

Өгүүлэн буй сэдвээс түр хөндийрч, "Ил хаан" гэсэн нэрийн талаар товч тайлбар хийе. Эзэн богд Чингис хааны отгон хөвгүүн Тулуйн хүү, Мөнх, Хубилай хаан нарын дүү Хулагу (Хүлэгү, Үлэхү) Ираныг байлдан дагуулахаар хөдөлсөн Монголын эзэнт гүрний их цэргийг манлайлан удирдаж явсан бөгөөд 1256 онд Ираны сүүлчийн түшиг тулгуур болж байсан Исмайлитын улсыг бут ниргэжээ. Тэрхүү газарт оршин тогтносон Хулагугийн улсын хааныг "ил хаан" (улсын эзэн, иргэний эзэн) гэж нэрийддэг байсан тул түүхэнд "Ил хаадын улс" хэмээн алдаршсан байна.

Дээр дурдсан жишээ баримтаар эш үндэс хийж, өнөө цагийн өнгөнөөс урагш улируулан үзвэл, тухайн үед энгийн ардын дунд ч, эзэнт төрийн хэрэгт ч "за" л гэсэн бол түүндээ хүрч, түүнийг даган мөрдөх ёстой хэмээх чанд хатуу цаазтай байсан нь тодорхой байна.

Ерөөс, монголчуудын андгайлж тангараглах ёс нэн эртний уламжлалтай бөгөөд хэн бүхний сайн мэдэх аман зохиолын нэгэн тодорхой жишээ бол "Эрхий мэргэний домог" юм. Тодруулан хэлбэл, Эрхий мэргэн тэнгэрт гарсан долоон нарыг харван устгах ам гарсан боловч нэгэн нарыг эс чадан үлдээсэн тул "за бололцсон" ёсоор эрхий хуруугаа огтолж, хар ус уухгүй, хагд өвс идэхгүй амьтан болон хувирч буй хэрэг билээ.

Манай ард түмэн хэлсэн ярьсан зүйлдээ эзэн болж чаддаг хүнийг өөр бусдаас онцгойлж үздэг нь тохиолдлын хэрэг биш, угаас монголчуудын хүнийг үнэлэх үнэлэмжийн хувьд эртнээс баримталж ирсэн гол шалгуур болно.

Энэхүү тогтвортой хэллэгийн орчин цагийн монгол хэлэн дэх үлдэл хоцрол нь "За гэвэл ёогүй" [Утга нь: За гэсэн бол түүнийгээ заавал биелүүлэх ёстой. Хэлсэн үгэндээ заавал хүрэх ёстой.], "За зэ болох" гэсэн цэцэн үгсэд байна. Түүнчлэн, "Тангараг нь тонгорог болох", "Ам

⁸ L.Ligeti, *Monuments préclassiques-I*, XIII^e et XIV^e siècles, Budapest, 1972, 252-253; А.Мостарт, Ф.В.Кливс, *Илхаан Аргун, Өлзийт нараас 1289, 1305 онд Гоо Филиппт илгээсэн захидлууд*, Франц хэлнээс орчуулсан Т.Төмөрхүлэг, Улаанбаатар, 1998, 85-86.

алдвал барьж болдоггүй, агт алдвал барьж болдог", "Хэлсэн үгэндээ эзэн болж, идсэн хоолондоо сав болох" зэрэг зүйр цэцэн үгс нь дурдан буй хэллэгийн утга санааг тодорхой хэмжээгээр агуулах ажээ. Өөрөөр хэлбэл, тэдгээр тогтвортой хэллэгийн эх үүдэл нь "за"-тай шууд хамааралтай буюу түүний түүхэн утгыг орчин цагийн монгол хэлэнд тээн авчирсан хэрэг билээ.

Мөн монгол хэлшинжлэлийн бүтээлүүдэд баймж үг, өгүүлбэрийг угтан чимэх үгэнд оруулан тооцдог "заавал" хэмээх үг нь бүтцийн хувьд "за+бол" гэсэн нийлэмжээс бүрдсэн бөгөөд "за"-ийн эртний утгыг орчин цагийн монгол хэлэнд хадгалж үлдсэн нэгж юм. Тийм учраас, эрдэмтэн Ю.Мөнх-Амгалан, тус үгийг зайлшгүй баймж утгыг илрүүлэх хэрэглүүрт оруулан тооцжээ⁹. Монгол бичгээр " ᠵᠠᠪᠣᠯ " гэж бичдэг. Урт эгшгийг тэмдэглэх зарчмыг баримталбал, "загабал" (ᠵᠠᠭᠠᠪᠠᠯ) байх ёстой. Үүнээс үүдэж, үгийн язгуур гарлыг тодруулахад анхаарч үзүүштэй чухал баримтын нэг бол монгол бичгийн уламжлалт буюу өвөрмөц бичлэгтэй хэлбэр гэдгийг тэмдэглэн хэлье. Тус үгийн бүтэц нь $\text{ᠵ} + \text{ᠪᠣᠯ} = \text{ᠵᠠᠪᠣᠯ}$ юм.

Түүнчлэн, монгол бичгийн хэлний "буй за" (ᠪᠤᠢ ᠵᠠ) хэмээх тогтвортой хам бүтцээр төгссөн өгүүлбэрүүд зайлшгүй баймж утгыг илтгэдгийн уг учир нь дурдан буй нэгжийн язгуур шинж чанартай шууд холбогдох зүйл болно.

Орчин цагийн монгол хэлний баймжийг айг тусгайлан судалсан бүтээлд, "өгүүлэгч нь харилцагчийн үзэл бодол, хүсэл эрмэлзэл, таашаал үнэлэмжийг хүлээн авч тухайн өгүүлэмжийн агуулгыг зөвшөөн зөвт үзэж, дагалдан санал нийлэлцэх шинжтэй утгыг"¹⁰ илтгэх гол хэрэглүүрт "за, зүйтэй, зөв" гэх мэт үгийг оруулан тооцож, түүнийг нэмэлт баймж чанарын зөвшөөрөх утгад хамаарна гэж дурджээ.

Эцэст дүгнэн хэлбэл, "за" хэмээх нь илрэх хэлбэрийн хувьд хоёрхон үсгээс бүтсэн боловч илтгэх утгын талаар амлан хэлэлцсэнээ алгасалгүй гүйцэтгэхийн шийдэл санаа бүхий андгай тангарагтай дүйх нэгэн цогц хэлц өгүүлбэр байсныг монгол хэлний түүхэн хөгжлийн дурсгал дахь бодот баримт нуталж байна.

Үнэхээр, орчин цагийн монгол хэлэнд даган зөвшөөрөх санааг илтгэх "за"-ийн уг утга нь монгол хэлний эртний үед "хэлсэн үг, хийсэн хэрэгтээ эзэн байх"-ын үнэлэмж бүхий "андгай тангараг" байсан нь бидний өвөг дээдэс найман зууны тэртээ дэлхий дахинаа хүчирхэгжин мандахад нэмэр түлхэц болсон олон хүчин зүйлийн нэг нь лавтай мөн. Өвөг дээдэс маань "за андгаартан" байсныг нэхэн санаж, "за"-даа эзэн болж байхын учир утгыг залуус бид ухааран сэхээрэх нь туйлын чухал билээ.

⁹ Ю.Мөнх-Амгалан, *Орчин цагийн монгол хэлний баймжийн ай*, Улаанбаатар, 1998, 105-109.

¹⁰ Ю.Мөнх-Амгалан, *Орчин цагийн монгол хэлний баймжийн ай*, Улаанбаатар, 1998, 231-235.

RESUME

In this article, the author has analysed the usage of "za" in Mongolian historical sources and monuments. The ancient version of "za" is different from modern spoken Mongolian. It has a similar meaning to "oath" or "to keep one's promise". This stable expression's meaning is still found in modern Mongolian proverbs such as "За гэвэл ёогүй" (If you say 'Yes' don't sigh 'Oh'), "Хэлсэн үгэндээ эзэн болж, идсэн хоолондоо сав болох" (Keep one's promise and digest one's food = Be slow to promise and quick to perform) etc.

'Zaaval' is the modern Mongolian modal, which also has the meaning of the ancient version of 'za'. It's structure is 'za+bol'.